



ЭЗЭНГҮЙ ХОГНЫ ТАЙЛАН

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын экосистемийг хог хаягдлын менежментээр дамжуулан хамгаалах төсөл

ХОГ ХАЯГДЛЫН СУРГАЛТ

ХОГ АНГИЛАН ЯЛГАХ БАЙГУУЛАМЖ

ДУГУЙ ШИРЭЭНИЙ УУЛЗАЛТ БОЛОН
ХЭЛЭЦҮҮЛЭГ

ЭЗЭНГҮЙ ХОГНЫ ТАЙЛАН

ХОГНЫ УУТНЫ ТАЙЛАН

УРАЛДААН, УРАМШУУЛАЛЫН ТАЙЛАН

“ХӨВСГӨЛ НУУРЫН
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙГ
ХОГ ХАЯГДЛЫН
МЕНЕЖМЕНТЭЭР
ДАМЖУУЛАН ХАМГААЛАХ”
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР



Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын экосистемийг хог хаягдлын менежментээр дамжуулан хамгаалах төслийн хүрээнд нуурын баруун эргийн эзэнгүй хог хаягдлыг Эко-Дэвшилт ТББ-ын Хатгал дахь салбарын ажилчид 2021 онд нийтдээ 9.4 тонн хог хаягдлыг 11 удаагийн гаралтаар цэвэрлэсэн байна.

2021-04-09 Хатгал тосгоны бүх нийтийн хог цэвэрлэгээнд Эко-Дэвшилт ТББ Гал түймэр унтраах ангийн гал сөнөөгч Энхбаяртай хамтран Нефтээс Сэлэнгэ жуулчны бааз хүртэлх зам дагуу эзэнгүй хог хаягдал цэвэрлэлээ. Цахир толгойн урд хэсэг ой модтой хэсгээр маш их хог байна.



2021-05-12 Жолооч Ц.Батсүх Жанхайн зам дагуу эзэнгүй хог хаягдал түүсэн.Жуулчны баазуудын үйл ажиллагаа эхлээгүй байсан тул эзэнгүй хог хаягдал харьцангуй гайгүй байна.



2021-05-18 Хатгалын оффис орчимын эзэнгүй хогоо түүлээ.



2021-05-24 Жолооч Ц.Батсүх Хүзүүвчийн шил дэхь эзэнгүй хог хаягдал цэвэрлэсэн. Хүзүүвчийн шилд 5 жуулчны бааз байдаг нутаг дэвсгэрийн хувьд бага тул эзэнгүй хог хаягдал маш бага байсан.



2021-05-27 Хатгал тосгоны бүх албан байгууллага болон төрийн бус байгууллага, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүд Харганы хогийн цэг орчим, Эгийн голын эрэг дагуу ,Улаан мод орчим бүх нийтийн хог цэвэрлэгээ боллоо.Эко-Дэвшилт ТББ-ын хамт олон бид уг цэвэрлэгээнд хүн хүч болон машин техникийн туслалцаа үзүүлэн идэвхитэй оролцлоо.



2021-08-05 Хөвсгөлийн аялал жуулчлал эрхлэгчдийн холбоо хаалтын үйл ажиллагаа хийж байгаатай холбогдуулан Эко-Дэвшилт ТББ-ын ажилчид бид тус холбооныхонтой хамтран Жанхайд байрлах Дээд модот булангийн эзэнгүй хог хаягдлыг түүж цэвэрлэлээ.Эзэнгүй хог хаягдал цэвэрлэх үйл ажиллагаанд дараахь жуулчны бааз, иргэн хамрагдсан болно.Үүнд:

- Байгаль-Үүд жуулчны бааз
- Тойлогт жуулчны бааз
- Баян-Улаан жуулчны бааз
- Мишээл гэр буудал
- Гранд- Тур жуулчны бааз
- Далайн-гялбаа жуулчны бааз
- Гурван-Эрдэнэ жуулчны бааз
- Ногоон-ертөнц гэр буудал
- Art-88 жуулчны бааз
- Эко-Дэвшилт ТББ
- Иргэн П.Баттулга нар оролцсон болно



Эко-Дэвшилт ТББ-ын Ангилан ялгагч Д.Баттөр, жолооч Ц.Батсүх, менежер Ч.Мандухай, сургагч багш Б.Мөнгөнтулга, байгаль хамгаалагч Д.Пүрэвсүрэн, ангилан ялгагч Д.Ууганбаяр бид эзэнгүй хог хаягдлыг 4 өдрийн турш цэвэрлэсэн .

2021-08-27 Хясаан постоос – Хөх сувд жуулчны бааз хүртэл

2021-08-28 Хөх-сувд жуулчны баазаас – Жанхайн даваа хүртэлх

2021-08-29 Жанхайн даваанаас – Улаан мод хүртэлх

2021-08-31 Хүзүүвчийн шил




2021-09-17 Хатгал тосгоны Захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан Бүх нийтийн хог цэвэрлэгээнд оролцлоо. Манай байгууллага Соёлын төв, Урандөш хүүхдийн цэцэрлэг, Цэвдэг судлал, Нутгийн урчуудтай хамтран Нэвтрэх цэгээс Алаг-Уул хүртэлх хог хаягдлыг цэвэрлэлээ.



Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын экосистемийг хог хаягдлын менежментээр дамжуулан хамгаалах төслийн хүрээнд нуурын баруун эргийн эзэнгүй хог хаягдлыг Эко-Дэвшилт ТББ-ын Хатгал дахь салбарын ажилчид 2022 онд нийтдээ 10.3 тонн хог хаягдлыг 6 удаагийн гаралтаар цэвэрлэсэн байна.



2022-06-25 Хатгал Эко-Дэвшилт ТББ-ын багийхан бид Жуулчны баазуудын нээлтийг тохиолдуулан ХУТХГ ХЗ-ны хамт олноос зарласан Эзэнгүй хог хаягдал цэвэрлэх өдөрт Хясаан постоос Хатгал тосгоны Улаан мод хүртэлх хог хаягдлыг 2 өдөрт түүж цэвэрлэлээ.



2022-07-18 Аялал жуулчлал эхэлсэнтэй холбогдуулан амрагч аялагч нар ихээр ирсэн тул Эзэнгүй хог хаягдал ихээр үүссэн тул ээлжит хог хаягдал цэвэрлэгээндээ гарч Онголог тураас Хатгал тосгоны Улаан мод хүртэлх хог хаягдлыг түүж цэвэрлэлээ.



2022-08-09 Хоёр нарны хооронд ОУ-ын марафон гүйлт уралдаан болохтой холбогдуулан марафоны замын маршрутаар Эзэнгүй хог хаягдлыг түүж цэвэрлэлээ



2022-08-21 ХУТХГ ХЗахиргаа болон Хөвсгөлийн Аялал Жуулчлал Эрхлэгчдийн Холбоотой хамтран намрын баазуудын Хаалтын ажиллагааг тэмдэглэн Бүх нийтийн их цэвэрлэгээг хийж Эзэнгүй хог хаягдлыг олны хүчээр маш сайн цэвэрлэж авлаа.



2022-08-23 Хатгал тосгоны ЗАА-тай хамтран Хөвсгөл нуурын зүүн эрэг дагуу хог хаягдлын цэг үүссэн байсаныг цэвэрлэлээ.



2022-09-09 Хатгал тосгоны Захирагчийн Ажлын Албаны БОАЖ тасгаас зарласан Намрын албан байгууллагуудын нэгдсэн бүх нийтийн хог цэвэрлэгээнээд Ойн мэргэжлийн байгууллага ,Ойн нөхөрлөлүүдтэй хамтран Эгийн голийн гүүрнээс Нуурын босго хүртлэх голийн эрэг дагуу хог хаягдлыг цэвэрлэлээ.



2022-09-24 Бүх нийтийн хог цэвэрлэгээний хүрээнд Харганы хогын цэг болон Нүцгэн ногоон тал орчим цэвэрлэлээ



Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Холбоо барих: 99552947, 98890113

Хаяг: Хатгал тосгон, экоДэвшилт ТББ
Сургалт танин мэдэхүйн төв

